УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Г.ГАНБААТАР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 09 17, Факс: (976-51) 26 24 08
Цахим шуудан: info@cabinet.gov.mn
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2024.10.17 № ХЯГ/1998

Танай _____-ны №_____-т

Асуултын хариу хүргүүлэх тухай

Цагаандэл уул боомтын талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуултын хариуг холбогдох Засгийн газрын гишүүнээс бэлтгэж ирүүлснийг Танд хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцахыг хүсье.

Хавсралт 08 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.УЧРАЛ

000245017147

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА

МОНГОЛ УЛС
БООМТЫН СЭРГЭЛТИЙН
УЛСЫН ХОРОО

2024.10.14 № 01/996

Хариу хүргүүлэх тухай

Танаас ирүүлсэн Цагаандэл-Уул боомтын талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатарын асуултын хариуг дараах байдлаар хүргүүлж байна.

Тус хороо нь Монгол Улсын Засгийн газар эдийн засгийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэх, цар тахлын дараах эдийн засгийн сөрөг нөлөөг бууруулж, төр, хувийн хэвшил, хөрөнгө оруулагчдын идэвхтэй түншлэлд тулгуурлан хөгжлийг хязгаарлаж буй 6 багц асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэх зорилгоор батлагдсан эдийн засаг, дэд бүтэц болон төрийн бүтээмжийг сайжруулах дунд хугацааны зорилтот хөтөлбөр болох "Шинэ сэргэлтийн бодлого"-ын тэргүүлэх зорилтын нэг болох "Боомтын сэргэлтийн бодлого"-ын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын зүгээс Цагаандэл-Уул боомтын бүтээн байгуулалтын талаар дараах шийдвэрүүд гарсан байдаг. Үүнд:

1. Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн "Хилийн боомтын талаар авах арга хэмжээний тухай" 46 дугаар тогтоолд "***Монгол, Хятадын улсын хилийн дагуу Монгол Улсын талаас Өмнөговь аймгийн Хүрмэн сумын нутаг Цагаан дэл уулын чиглэлд, Хятадын талаас БНХАУ-ын ӨМӨЗО-ны Альшаа аймгийн Альшаа зүүн хошууны нутаг Өлзий уулын чиглэлээр хоёр талын зорчигч, ачаа тээврийн "Цагаан дэл уул–Өлзий" байнгын ажиллагаатай авто замын боомт шинээр байгуулахыг зөвшөөрсүгэй***" гэж;
2. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн худалдааны тэмдэглэлийн 2.9 дэх хэсэгт "***БНХАУ-ын ӨМӨЗО-ны Альшаа аймгийн буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж байгаа хилийн Цагаандэл-Уул боомтын бүтээн байгуулалтад шаардлагатай тоног төхөөрөмж, бараа материалыг хятадын талаас татах түр гарцыг зохих журмын дагуу нээж, сар бүрийн ажлын 10 хоног ажиллуулах талаар Хятадын талтай дипломат шугамаар тохиролцох, хэрэгжүүлэх, чиглэлээр ажиллахыг Гадаад харилцааны сайд, Сангийн сайд, Зам, тээврийн хөгжлийн сайд нарт даалгасугай***" гэж;

3. Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 01 дүгээр албан даалгаварт "***Цагаандэл-Уул боомтын үндсэн болон нэмэлт байгууламжийн төвлөрсөн цахилгаан хангамжийг дотоодын эх үүсвэрээс хангаж, дулаан хангамжийн нам даралтын зуухыг төвлөрсөн халаалтын системд холбох ажлыг үе шаттай зохион байгуулах арга хэмжээ авах***" гэж;
4. Монгол Улсын Засгийн газрын хуралдаанд 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдөр Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Өмнөговь аймагт ажилласан дүнгийн талаар Засгийн газрын гишүүдэд танилцуулсаны дагуу батлагдсан "Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Өмнөговь аймагт ажиллахдаа өгсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 7 дугаарт "***Хилийн Цагаандэл-Уул – Өлзий боомтын асуудлыг Өмнийн говийн хөгжлийн зөвлөлөөр хэлэлцэн санал, дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулах***" гэж;
5. Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 01 дүгээр албан даалгаварын 1.4.2.-т "***Цагаандэл-Уулын жишиг боомт байгуулах***" гэж;
6. Засгийн газар хөгжлийн тулгамдсан асуудал, тулгарч байгаа сорилтуудыг илүү хурдан, үр дүнтэй шийдвэрлэх, бүрэн эрхийнхээ хугацаанд бүтээлчээр, тогтвортой хамтран ажиллах зорилгоор Монгол Ардын нам, Ардчилсан нам, ХҮН намын хооронд байгуулсан "ХУРДТАЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ЗОРИГ" хамтарсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр Улсын Их Хурлаар батлагдсантай холбогдуулан 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан 2024 онд багтаан хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тухай Монгол Улсын Ерөнхий сайдын 01 дүгээр албан даалгаварын 8.1-д "***Цагаандэл-Уул боомтын үйл ажиллагааг эхлүүлэх***" гэж тус тус заасан байдаг.

Монгол Улсын Засгийн газраас гарсан дээрх шийдвэрүүдийн хүрээнд Цагаандэл-Уул боомтын бүтээн байгуулалттай холбоотойгоор Боомтын сэргэлтийн үндэсний хорооноос дараах ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Үүнд:

1. Өмнөговь аймгийн Хүрмэн сумын нутаг дэвсгэрт орших Цагаандэл-Уул боомтод БНХАУ-ын ӨМӨЗО-ны Альшаа аймгийн 114.6 сая юаны буцалтгүй тусламжаар нүүрс, эрдэс баялаг, ачаа тээврийн хэсэгт хүнд даацын 12 эгнээ бүхий автозам, аялал жуулчлал, зорчигч нэвтрүүлэх хэсэгт 6 эгнээ автозам болон боомтын барилга байгууламж, шугам сүлжээ, суурьшлын бүсийг төлөвлөн, холбогдох ажлуудыг эхлүүлээд байна. Хөрөнгө оруулагч талаас явуулсан сонгон шалгаруулалтын үр дүнгээр Нарийвчилсан зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээг "Өрнөл проект" ХХК-тай, Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайлан боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээ "Эн Би Си Си" ХХК-тай 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр байгуулсан. Хилийн боомт орчмын нийт 130га талбайд Хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээг 2023 оны 05 дугаар сарын 13-ны өдөр хөрөнгө оруулагч талаас сонгон шалгаруулсан "Идеал групп" ХХК-тай байгуулсан.
2. "Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Өмнөговь аймагт ажиллахдаа өгсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 7 дугаарт

"***Хилийн Цагаандэл-Уул – Өлзий боомтын асуудлыг Өмнийн говийн хөгжлийн зөвлөлөөр хэлэлцэн санал, дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулах***" гэсний дагуу Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Хилийн боомтын захиргааны дарга Б.Батхишиг болон холбогдох албаны төлөөлөл 2023 оны 5 дугаар сарын 27-ны өдөр Өмнөговь аймагт тус аймгийн Номгон, Даланзадгад сумын иргэд, аж ахуйн нэгжийн төлөөллүүдтэй уулзалт зохион байгуулж "Боомтын Сэргэлт"-ийн хүрээнд хийж хэрэгжүүлж буй үйл ажиллагаа болон Цагаандэл-Уул боомтын бүтээн байгуулалтын талаар иргэд аж ахуйн нэгжид мэдээлэл хийж, санал солилцсон.

3. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн худалдааны тэмдэглэлийн 2.9 дэх хэсэгт БНХАУ-ын ӨМӨЗО-ны Альшаа аймгийн буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж байгаа хилийн Цагаандэл-Уул боомтын бүтээн байгуулалтад шаардлагатай тоног төхөөрөмж, бараа материалыг хятадын талаас татах түр гарцыг зохих журмын дагуу нээж, сар бүрийн ажлын 10 хоног ажиллуулах талаар Хятадын талтай дипломат шугамаар тохиролцох, хэрэгжүүлэх, чиглэлээр ажиллахыг Гадаад харилцааны сайд, Сангийн сайд, Зам, тээврийн хөгжлийн сайд нарт даалгасаны дагуу 2022 онд БНХАУ-ын талтай тохиролцож Цагаандэл-Уул-Өлзий авто замын боомтыг сар бүрийн 15-25-ны өдрүүдэд нээн ажиллуулахаар тохиролцсон. Мөн Монгол, Хятадын хилийн боомтын менежментийн хамтын ажиллагааны комиссын тавдугаар хуралдааны үеэр уг асуудлыг хэлэлцэж Цагаандэл-Уул боомтыг 2023 оны 8 дугаар сараас эхлэн сар бүрийн 15-25-ны өдрүүдэд түр ажиллуулахаар тогтсон. Хуралдааны үеэр Цагаандэл-Уул боомтыг ийнхүү түр хугацаагаар нээн ажиллуулах нь тус боомтын бүтээн байгуулалт, нээн ажиллуулах үйл явцыг түргэтгэх ач холбогдолтойг дурдсан бөгөөд талууд тус тусын дотоодын процедурыг хөнгөвчилж, 2023 оны багтаан БНХАУ-ын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэх Цагаандэл-Уул боомтын зураг төсөл боловсруулах, батлуулах ажлыг дуусгах, 2024 онд багтаан ашиглалтанд оруулахын төлөө чармайн ажиллахаар тохиролцсон.

4. Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 3 дугаар хуралдааны 3 дугаар тэмдэглэлд Цагаандэл-Уул боомтын бүтээн байгуулалтын барилга угсралтын ажилд шаардлагатай техник, тоног төхөөрөмж, бараа материал, ажиллах хүчийг хилээр нэвтрүүлэх зорилгоор тус боомтыг гүр горимоор нээн ажиллуулахтай холбоотойгоор цагийн хуваарийн өөрчлөлтийг БНХАУ-ын талтай харилцан тохиролцохыг Гадаад харилцааны сайд, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Гадаадын иргэн, харьяатын газрын дарга нарт тус тус даалгасан.

5. Боомтын сэргэлтийн Үндэсний хорооноос Цагаандэл-Уул боомтыг түр горимоор ажиллуулахтай холбоотойгоор бодит нөхцөл байдал, албан хаагчдын ажиллах, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах талаар холбогдох арга хэмжээнүүдийг газар дээр нь авч хэрэгжүүлсэн.

6. 2024 оны 01 дүгээр сарын 23-24-ны өдрүүдэд БНХАУ-ын Бээжин хотноо БНХАУ-ын талтай хийсэн газрын дарга нарын түвшний есдүгээр уулзалтын үеэр БНХАУ-ын талаас "Өлзий" боомтын авто замын боомтын дэд бүтцийн бүтээн байгуулалт дууссаныг мэдэгдэж, монголын талд "Цагаандэл-Уул" боомтын холбогдох цогцолбор, тээврийн авто замын дагалдах

байгууламжийг 2024 онд барьж дуусгах хүсэлтийг тавьсан. Монголын тал холбогдох байгууллага, орон нутгийн зүгээс дотоодын зохицуулалт, бүтээн байгуулалтыг түргэтгэн, боомтыг аль болох эрт албан ёсоор нээхэд анхаарч ажиллахаа илэрхийлсэн.

Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатарын асуултын 3-т заасан концессын гэрээтэй холбоотой асуудал нь Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудалд хамаарах тул Эдийн засаг, хөгжлийн яамнаас тодруулга, мэдээлэл авах нь зүйтэй байна.

Цагаандэл-Уул боомтын бүтээн байгуулалттай холбоотойгоор боомт дээр хийгдэж байгаа ажлуудын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргав.

Хавсралт ... хуудастай

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН САЙД,
БООМТЫН СЭРГЭЛТИЙН ҮНДЭСНИЙ
ХОРООНЫ ДАРГА Б.ТУЛГА

Боомтын сэргэлтийн үндэсний хорооны
2024 оны 10 -р сарын 19 өдрийн 01/746 тоот
албан бичгийн хавсралт

Цагаандэл-Уул боомтын бүтээн байгуулалттай холбоотойгоор боомт дээр хийгдэж байгаа ажлуудын мэдээлэл

/2024 оны 09 дүгээр сарын 30-ны байдлаар/

- Цагаандэл-Уул боомт 2024 оны 07-р сарын 16-ны өдрөөс сарын хугацаатай түр нээгдэж боомтын бүтээн байгуулалтын ажилчдын түр амьдрах сууц болон хэрэглэгдэх бараа материал орж ирсэн. Мөн 20 ажилтан өглөө орж ирээд тухайн өдрөө гарах зохицуулалтаар ажилласан.
- Цагаандэл-Уул боомтыг 07 сарын 16-ны өдрөөс сарын хугацаатай түр нээж боомтын бүтээн байгуулалтын бэлтгэл ажлыг хангахад шаардлагатай барилгын материалуудыг хилээр нэвтрүүлсэн.
- 2024 оны 08 дугаар сарын 08-ны өдөр БНХАУ-ын ӨМӨЗО-ны Альшаа аймгийн Өлзий боомтын зүгээс 2024 оны 08 дугаар сарын 15-ны өдрөөс Цагаандэл-Уул боомтын бүтээн байгуулалтыг ажлын хүрээнд талбай тэгшлэх ажлыг гүйцэтгэхэд боомтыг 2024 онд түр горимоор нээн ажиллуулах хүсэлтийг Монгол Улсын Сангийн яам, Хөгжлийн хөтөч-дэд бүтэц төсөл, ХХЕГ, ГЕГ, ГИХГ-т уламжилж өгөхийг хүссэн. Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны даргын 2024 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 01/748 албан тоотоор дээрх байгууллагуудад Цагаандэл-Уул боомтыг 2024 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл нээн ажиллуулах хүсэлтийг дэмжиж, хамтран ажиллах албан тоотыг илгээсэн.
- Цагаандэл-Уул боомтын бүтээн байгуулалтын бэлтгэл ажлыг хангах зорилгоор түр нээн ажиллуулах хугацааг 1 сараар сунгасан. Энэ хугацаанд Цагаандэл-Уул боомтод ажиллаж боомтын ажлын нөхцөл байдлын талаар холбогдох байгууллагын дарга удирдлагуудад танилцуулж шийдвэрлэх арга хэмжээ авч ажилласан.
- Бүтээн байгуулалтын ажилд оролцож байгаа ажилчдын ажиллах, амрах түр сууцад хийгдэх шаардлагатай ажлууд хийгдэж дууссан.
- Боомтын үерийн хамгаалалтын далан шуудууг нөхөн сэргээх, талбайн тэгшилгээний ажил, хашааны битүүмжлэлийг сайжруулж шон, тор хаалга нэмж суурилуулах ажил, Хил хамгаалах байгууллагын 15 метрийн өндөр 2ш гэрлийн цамхгийг суурилуулах ажил, камер суурилуулалтын ажлууд хийгдсэн.
- Боомтын түр гарцын авто пүүг Стандарт, хэмжил зүйн газраас 2024.04.09-ны өдөр баталгаажуулж гэрчилгээ олгосон.
- Цагаандэл-Уул боомтын бүтээн байгуулалтын бэлтгэл ажлыг хангах зорилгоор түр нээн ажиллуулах хугацааг 2024 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс 11 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэл 2 сараар сунган ажиллуулах саналыг хятад талаас тавьж шийдвэрлэн ажилласан.
- Түр горимоор ажиллах хугацааг сунгаснаас хойш ачаа тээврийн авто замын суурийн ажил хийгдэж байна.

- Боомтын бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай бетон зуурмагийн болон бутлуурын үйлдвэрийн тоног төхөөрөмжийг оруулж ирэн, угсарч суурилуулах, туршин ажиллуулах бэлтгэл хангагдаж байна.
- Хятад тал Цагаандэл-Уул боомтын бүтээн байгуулалтыг гүйцэтгэх аж ахуйн нэгжээр "Жунмэй Инженеринг групп" ХХК-ийг сонгон шалгаруулсан бөгөөд 2024 оны 11 дүгээр сард БНХАУ-ын ӨМӨЗО-ны Альшаа аймгийн Өлзий боомтод Цагаандэл-Уул боомтын бүтээн байгуулалтын нээлтийн үйл ажиллагааг хийх саналыг хятад талаас тавиад байна.
- Боомтын зураг төслийн ажлын хүрээнд ТЭЗҮ экспертизээр хянагдаж дүгнэлт гарсан.
- БОННҮ-ний тайланг хянуулахаар БОУАӨЯ-нд хүсэлтээ илгээсэн.
- Боомт орчмын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын техникийн зөвлөлийн хурлаар хэлэлцэгдсэн. Хөрөнгө оруулагч талаас санал гарч, зураг төсөлд нэмэлт өөрчлөлт орсон. Нарийвчилсан зураг, төсвийн ажлын явц 82%-тай байна.

77

МОНГОЛ УЛСЫН
ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ
Засгийн газрын Хүүхдийн гудамж 11,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 33 33,
Цахим шуудан: info@med.gov.mn

2024. 10. 15 № 03/2117

танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА

Хариу хүргүүлэх тухай

Танаас 2024 оны ХЭГ/1913 дугаартай албан бичгээр ирүүлсэн Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатарын "Шинэ хилийн боомт нээх талаар" тавьсан асуултуудтай танилцлаа.

Улсын Их хурлын гишүүн Г.Ганбаатарын асуусан 3 дугаар асуулт нь тус яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах тул дараах хариу, мэдээллийг хүргүүлж байна.

Засгийн газрын 2018 оны 330 дугаар тогтоолоор эрх олгосны дагуу тухайн үеийн концессын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Үндэсний хөгжлийн газар болон "Ундрах говь" ХХК-ийн хооронд "Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс "Цагаандэл уул" хилийн боомт хүртэлх 270 км авто зам төсөл"-ийн концессын гэрээг 2018 оны 12 дугаар сарын 04-ний өдөр байгуулсан. Одоогийн байдлаар концессын гэрээ хэрэгжих урьдчилсан нөхцөл хангагдаж, концессын гэрээ хүчин төгөлдөр болсон, авто замын техник, эдийн засгийн үндэслэл болон зураг төсөл хийгдэж батлагдсан. Төслийн барилга угсралтын ажил тус хилийн боомт болон авто зам барихыг эсэргүүцсэн орон нутгийн ард иргэдийн эсэргүүцэл, цар тахал зэрэг /уг төсөлд цар тахал буюу давагдашгүй хүчин зүйл нөлөөлсөн тухай "Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим" НҮТББ-ын 2020 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 02/701 дугаар "Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн гэрчилгээтэй/ шалтгаануудаар хугацаандаа эхлээгүй.

Мөн 2022 онд Монгол Улсын Ерөнхий сайд Өмнөговь аймагт ажиллаж, Даланзадгад хотод иргэдтэй хийсэн уулзалтын үер "Цагаандэл уул" хилийн боомт руу чиглэсэн авто замын асуудлыг эргэн харах талаар мэдэгдэж, улмаар Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн хуралдааны 31 дүгээр тэмдэглэлээр Монгол Улсын Ерөнхий сайдын Өмнөговь аймагт ажиллахдаа өгсөн үүрэг, чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгасан бөгөөд тус төлөвлөгөөний 7 дугаарт "Хилийн "Цагаандэл уул-Өлзий" боомтын асуудлыг "Өмнийн говийн хөгжлийн зөвлөл"-өөр хэлэлцэн, санал дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулах" гэж туссан. Энэ асуудлыг шийдвэрлэж, "Өмнийн говийн хөгжлийн зөвлөл"-өөр хэлэлцүүлэх талаар тус яамнаас Боомтын сэргэлтийн үндэсний хороонд 2023 оны 02/503, 2024 оны 03/387 дугаар албан бичгүүдийг хүргүүлсэн боловч тодорхой шийдвэр гараагүй байна.

Төслийн концесс эзэмшигч "Ундрах говь" ХХК-аас 2024 оны 24/22 дугаар албан бичгээр концессын гэрээнд заасан барилга угсралтын ажлын хугацааг сунгах хүсэлт ирүүлсэн.

242762

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу концессын гэрээг сунгах хүсэлтийг Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Энэ үеэр тус боомт руу чиглэсэн төмөр зам, авто замын төслүүд шинээр хэрэгжүүлэх талаар Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан танилцуулсан бөгөөд Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн хуралдааны 35 дугаар тэмдэглэлд "...Цагаандэл уул боомт чиглэлийн төмөр зам, тусгай зориулалтын авто зам барих төсөлтэй холбогдуулан тулгамдаж байгаа асуудлыг газар дээр нь судалж, орон нутгийн иргэд, иргэний нийгмийн байгууллагатай уулзалт хийж, нэгдсэн ойлголцолд хүрэх арга хэмжээг авч, үр дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг ажлыг холбогдох сайдуудыг оролцуулан шуурхай зохион байгуулахаар тогтов" гэж тусгасан.

Энэ хүрээнд даалгасан ажлыг зохион байгуулж, газар дээр нь ажиллахаар холбогдох бэлтгэл ажлыг хангаж байна.

Жич: Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр гадаад томилолтоор ажиллаж байна.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА И.БАТХҮҮ